

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 26

Улаанбаатар хот

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Epr.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 180 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд:

- ✓ иргэнээс 162 өргөдөл
- ✓ албан хаагчаас 18 өргөдөл

Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 178 буюу 98 хувь, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 өргөдөл гомдол, судлагдаж байгаа 1 буюу 1 хувь өргөдөл, гомдол байна.

Тайлант хугацаанд өдөрт нь багтаан шилжүүлээгүй 2, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 3, явцын тэмдэглэл хөтлөөгүй 5 зөрчил бүртгэгдсэн.

Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 өргөдөл, гомдол байна.

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 13 хоног 7 цаг 49 минут байна.

Өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 12,6 хувиар буурсан үзүүлэлттэй, зөрчил 26,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Графикаар харуулбал:



Тайлант хугацаанд “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

➤ Албан хаагчаас 18 хүсэлт ирүүлснээс:

Шийдвэрлэгдсэн: ажлаас чөлөөлөгдөх 2 хүсэлт, нийгмийн асуудал шийдвэрлүүлэх 2 хүсэлт, цалинтай чөлөө хүссэн 3, цалингүй чөлөө хүссэн 6, сургалтад хамрагдах хүсэлт 1, хүүхэд асрах чөлөө сунгах тухай 4, ирүүлснийг Ахлах мэргэжилтэн А.Солонго, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Түвшинжаргал нар тухай бүрт нь газрын даргын тушаалаар 100 хувь шийдвэрлэн ажиллав.

➤ Иргэнээс 162 өргөдөл, гомдол ирүүлсэнээс:

Зураг төсөл, барилга байгууламж, засвар, тохижилт хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой 155 өргөдөл гомдол, ажилд орох хүсэлт 7 ирүүлснийг 160 өргөдөл, гомдол хугацаандаа шийдвэрлэгдэж, 1 өргөдөл гомдол хугацаа хэтрүүлэн шийдвэрлэгдсэн, 1 өргөдөл, гомдол судлагдаж байна. Үүнд танилцуулбал: